



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/99/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа
		Цахим хаяг: smaudit97@gmail.com
	Аудитор:	Б.Ариунбаатар
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022. 02.25 № 46/237

танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Б.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	64.52	185.60
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	390.31	445.69
	Нийт хөрөнгийн дүн	454.83	631.29
	Нийт өр төлбөрийн дүн	-	18.17
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	454.83	613.12
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	454.83	631.29
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	517.45	731.82
	Үйл ажиллагааны зардлын дүн	332.22	540.09
	Үйл ажиллагааны үр дүн	185.23	191.73
	Үйл ажиллагааны бус үр дүн	(4.59)	(33.44)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	180.64	158.29
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277.57	454.83
	Тайлант оны үр дүн	177.26	158.29
	Эцсийн үлдэгдэл	454.83	613.12
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	339.86	399.88
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	333.22	380.44
	Үйл ажиллагааны ЦМГ	6.64	19.44
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(3.22)	(4.04)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3.42	15.40
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15.40
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		333.25
	Урсгал зардал		333.25
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		348.60
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		348.60
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээг чанартай тасралтгүй үзүүлж ээлтэй, ая тухтай орчинд чанартай хүргэх зорилготой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт дутуу олгогдсоноос ковидын тандалт судалгаа, дархлаажуулалт болон шинжилгээ үйлчилгээний зардалд 91.4 сая төгрөгийн авлага, эм бэлдмэлийн зардалд 18.0 сая төгрөгийн өглөг тус тус үүссэн байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 149 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 333.2 сая төгрөгийн буюу давхардсан тоогоор 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 10,671.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,709.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 962.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

1. Үр дүнгийн тайланд тусгагдсан цалин хөлсний зардлыг 6,477.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. Тус алдааг аудитын явцад залруулав.
2. НДШ-ийн зардлыг 3,232.3 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн бөгөөд үүнийг авлагаар тусгаагүй байна. Аудитаар алдааг залруулж авлагаар бүртгэв.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлсний зардалтай холбоотой асуудал

- а. Илрүүлэлт: Харилцах данснаас шилжүүлсэн цалин, гарт олгох цалин хооронд 392.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.
- б. Өгсөн зөвлөмж: Цалингийн зардлыг тооцооны зардлаар дамжуулан бүртгэж байх.

2. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: Цалингийн зардлаас 2020 онд зарцуулагдаагүй үлдсэн 9,267.6 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж авлагаар тусгасан байна. Тайлант онд энэхүү авлагаар татварын өр төлбөрийг барагдуулсан бөгөөд 569.9 мянган төгрөгийн өр төлбөрийг дутуу тооцсон байна.
- 1.2 Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийн дансны үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулж байх.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төв	4	10.6	2	9.7	-	-	-	-	2	0.9